БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/07/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024 оны 02 дугаар сар | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын<br>Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат<br>Утас:70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**Асуудлыг онцолсон хэсэг** ..... 4
**Аудитын гол асуудал** ..... 4
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 9
**4.1 Ерөнхий зүйл** ..... 13
**4.2 Материаллаг байдал** ..... 14
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 14
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ..... 14
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 14
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 14
**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 14
*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 15
**5. Аудитын илрүүлэлт** ..... 15

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/55

танай__________-ны № __________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХАЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Э.ЭНХТӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно

**Аудитын гол асуудал**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдан зээл авсан иргэд, аж ахуйн нэгжийн 2023 онд зээлийн эргэн төлөгдөх хугацаа дууссан 43 зээлдэгчийн 106,573,000 зээлийн авлагын үлдэгдлийн хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 23

5020212

арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ХХҮЕГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар |
| ХХҮГ | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар |
| ХЭДС | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ХБИ | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,057,657,056.00** | **2,752,202,147.00** |
| **33** | **АВЛАГА** | 2,057,657,056.00 | 2,752,202,147.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 134,283,521.00 |
| **335** | **Бусад авлага** | 2,057,657,056.00 | 2,617,918,626.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,057,657,056.00 | 2,617,918,626.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,057,657,056.00** | **2,752,202,147.00** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,120,000.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,120,000.00 | - |
| **413** | **Өглөг** | 1,120,000.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 1,120,000.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,120,000.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,056,537,056.00** | **2,752,202,147.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,056,537,056.00 | 2,752,202,147.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,056,537,056.00 | 2,752,202,147.00 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,567,454,397.00 | 2,056,537,056.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 489,082,659.00 | 695,665,091.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,057,657,056.00** | **2,752,202,147.00** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,113,484,300.00** | **2,360,372,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,201,300.00** | **31,900,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 13,201,300.00 | 31,900,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 13,201,300.00 | 31,900,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,201,300.00 | 31,900,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,100,283,000.00** | **2,328,472,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 2,328,472,500.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | 2,328,472,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,100,283,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,100,283,000.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,624,401,641.00** | **1,664,707,409.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,624,401,641.00** | **1,664,707,409.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 64,999,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 64,999,900.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 64,999,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,624,401,641.00 | 1,599,707,509.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,095,153,851.00 | 1,012,459,079.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,095,153,851.00 | 1,012,459,079.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 529,247,790.00 | 587,248,430.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 529,247,790.00 | 587,248,430.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **489,082,659.00** | **695,665,091.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **489,082,659.00** | **695,665,091.00** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,117,101,300.00** | **2,366,497,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,201,300.00** | **38,025,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 13,201,300.00 | 38,025,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 13,201,300.00 | 31,900,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,201,300.00 | 31,900,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 6,125,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,103,900,000.00** | **2,328,472,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 3,617,000.00 | 2,328,472,500.00 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,617,000.00 | - |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | 2,328,472,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,100,283,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,100,283,000.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,526,401,641.00** | **2,928,235,930.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,526,401,641.00** | **2,928,235,930.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **64,999,900.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 64,999,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 64,999,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,526,401,641.00** | **2,863,236,030.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,997,153,851.00 | 2,141,704,079.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,997,153,851.00 | 2,141,704,079.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 529,247,790.00 | 721,531,951.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 529,247,790.00 | 721,531,951.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(409,300,341.00)** | **(561,738,430.00)** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 14 | **Бусад эх үүсвэр** | 409,300,341.00 | 561,738,430.00 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 409,300,341.00 | 561,738,430.00 |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **409,300,341.00** | **561,738,430.00** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 0.00 | 2,056,537,056.00 | 2,056,537,056.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **2,056,537,056.00** | **2,056,537,056.00** |
| C08 | **2022 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **2,056,537,056.00** | **2,056,537,056.00** |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **2,056,537,056.00** | **2,056,537,056.00** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **2,056,537,056.00** | **2,056,537,056.00** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 695,665,091.00 | 695,665,091.00 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **2,752,202,147.00** | **2,752,202,147.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,328,472,500.00 | 2,928,990,930.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,328,472,500.00 | 2,206,338,979.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 65,000,000.00 | 64,999,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 65,000,000.00 | 64,999,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 65,000,000.00 | 64,999,900.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,263,472,500.00 | 2,141,339,079.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,263,472,500.00 | 2,141,339,079.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,263,472,500.00 | 2,141,339,079.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | - | 722,651,951.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | | 722,651,951.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **8,000,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,000,000.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,000,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Байгууллагын эрхэм зорилго: Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Нийгмийн халамжийн зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж нийгмийн халамжийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхийн зэрэгцээ Хөдөлмөр эрхлэлтийн төрийн бодлого шийдвэртэй уялдуулж “Халамжаас-хөдөлмөрт” зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Сангийн батлагдсан төсвөөс тайлант онд “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд 6419 иргэд давхардсан тоогоор хамрагдсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг аймгийн ХХҮГ-ын дарга Э.Энхтөр, 2 дугаар гарын үсгийг ХЭДС хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Алтанцэцэг нар зурж, нярвын бараа материалын тайланг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Г.Сайханжаргал бэлтгэжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж, үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолын 2022.02.11-ний өдрийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөр" батлах тухай 01 дүгээр тогтоол;
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022.03.07-ны өдрийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/43 дугаар тушаал;
- 2022.03.27-ны өдрийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ арга хэмжээг 2022-2023 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж батлах тухай” А/54 дүгээр тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын даргын 2019.12.23-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь сангийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 490,202.7 мянган төгрөгөөр буюу 131.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,057,657.1** | **2,752,202.1** | 694,545.1 |
| АВЛАГА | 2,057,657.1 | 2,752,202.1 | 694,545.1 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,057,657.1** | **2,752,202.1** | 694,545.1 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,120.0** | - | (1,120.0) |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,056,537.1** | **2,752,202.1** | 695,665.1 |
| **Засгийн газрын хувь оролцоо** | 2,056,537.1 | 2,752,202.1 | 695,665.1 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,057,657.1** | **2,752,202.1** | 694,545.1 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Эх сурвалж: 2023 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөртэй холбоотой авлагын үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Төсөл | Авлагын эхний үлдэгдэл | Тайланд онд олгосон санхүүгийн дэмжлэг | Төлсөн авлагын дүн | Авлагын эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ажлын байрыг дэмжих хөтөлбөр | 915,704.7 | 600,000.0 | 202,854.6 | 1,312,850.1 |
| 2 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр | 151,536.0 | | 44,505.9 | 107,030.1 |
| 3 | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 618,192.8 | 275,000.0 | 196,555.5 | 696,637.3 |
| 4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр | 185,901.4 | 72,000.0 | 42,441.6 | 215,459.8 |
| 5 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр | 165,175.0 | 175,000.0 | 59,557.0 | 280,618.0 |
| 6 | Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл | 11,995.2 | | | 11,995.2 |
| 7 | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 9,152.0 | | 3,828.6 | 5,323.4 |
| | ДҮН | 2,057,657.1 | 1,122,000.0 | 549,743.2 | 2,629,913.9 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайлан, харилцах дансны хуулга, мөнгөн хөрөнгийн журнал*

Оны эхний хөтөлбөртэй холбоотой авлагын үлдэгдэл 2,057,657.1 мянган төгрөгөөс тайлант хугацаанд 549,743.2 мянган төгрөгийн авлага төлөгдөн, тайлант онд шинээр нэмж олгосон 1,122,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн авлага нэмэгдсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн дэмжлэгт хамрагдан зээл авсан иргэд, аж ахуйн нэгжийн 2023 онд зээлийн эргэн төлөгдөх хугацаа дууссан 43 зээлдэгчийн 106,573,000 зээлийн авлагын үлдэгдлийн хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

Ажлын байр дэмжих зээлийг нэг иргэнд (5,000.0-10,000.0 мянган) нийт 96 иргэнд 600,000.0 мянган төгрөг, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 55 малчинд 275,000.0 мянган төгрөгийг олгож 196,555.5 мянган төгрөгийг эргэн төлүүлсэн байна.

Өмнөх оны өглөгийн үлдэгдэл 1,120.0 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 695,665.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 2,752,202.1 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төслийг боловсруулан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийг 4,000.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангуудын санхүүжилтийг 2,535,357.0 мянга, нийт 2,539,357.0 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

ХХҮЕГ-ын даргын 2023.03.06-ны өдрийн А/37 дугаар тушаалаар Баянхонгор аймаг дахь ХЭДС-ийн 2023 оны төсвийн хуваарийг 2,332,472.5 мянган төгрөгөөр баталсныг 2023 оны 11 дүгээр сард шинэчлэн 2,338,472.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 72102 (хөдөлмөр эрхлэлтийг дэмжих) хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгосон батлагдсан санхүүжилтийг бүрэн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,206,704.0 мянган төгрөг буюу 94 хувьтай байгаа нь ажил олгогчийн дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд батлагдсан төсвийг дутуу зарцуулсантай холбоотой байна. Энэ нь дараах шалтгаантай байна.

- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд заасан 25 болон түүнээс дээш тооны ажилтантай ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 2 хэсэгт тогтоосон хувиас давсан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн ажилд авч,12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас давсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор урамшууллыг тус бүр нэг удаа олгоно” гэсэн арга хэмжээ гараагүйгээс зардал 71,574.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрөөс 57,128.6 мянган төгрөгийн зардал хэмнэгдсэн ажил олгогчийн урамшуулал, түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, хүүхэд харах төвд түрээсийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд төлөвлөсөн хэмжээнд хүрч ажиллаагүйгээс хэмнэлт үүссэн байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр | 88,590.0 | 88,440.0 | 150.0 | 100% |
| 2 | Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 1,058,200.0 | 1,001,100.0 | 57,100.0 | 95% |
| 3 | ХБИ -ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 262,220.0 | 190,646.0 | 71,574.0 | 73% |
| 4 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 18,000.0 | 18,000.0 | - | 100% |
| 5 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | 175,000.0 | 175,000.0 | - | 100% |
| 6 | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | | | - | |
| 7 | Ногоон ажлын байр хөтөлбөр | 598,680.0 | 598,519.2 | 160.8 | 100% |
| 8 | Ажилд зуучлах | 34,282.5 | 34,282.5 | - | 100% |
| 9 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох,зөвлөгөө өгөх үйлчилгээ | 28,500.0 | 28,500.0 | - | 100% |
| ДҮН | | | | | 95 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн тохируулгын дэлгэрэнгүй тайлан*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 8,000.0 мянган төгрөг орж албан хаагчдад нийтлэг үйлчилгээний чиглэлээр сургалтад зориулагдан зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал,

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 2,338,500.0 мянган төгрөгийг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар буюу 35,077.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 24,554.2 мянган тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээллийг тулган шалгахад 2,335,428.0 мянган төгрөгийн орлогын 6 гүйлгээ, 2,555,076.4 мянган төгрөгийн 75 зарлагын гүйлгээ, өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой 7,231,771.9 мянган төгрөгийн /давхардсан/ 58 шийдвэрийг цахим сайтад байршуулсан байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 521,439.6 мянган төгрөгийн 11 зөрчил илэрч 346,682.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах 1 албан шаардлага, зөрчил давтан гаргахгүй байх 174,575.6 мянган төгрөгийн 7 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.05.24-ны өдрийн 459 дугаар албан бичгээр ирүүлсэн ба хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн аудитын системд /FAS/ оруулан хариуцсан ахлах аудитор Б.Должмаа хяналт тавин ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 3 | 346,682.0 | 3 | 346,682.0 | 100 |
| Албан шаардлага | 1 | 0 | 1 | 0 | 100 |
| Зөвлөмж | 7 | 174,575.6 | 7 | 174,575.6 | 100 |
| **Нийт дүн** | 11 | 521,439.6 | 11 | 521,439.6 | 100 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/54 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг 2022-2023 онд зохион байгуулах нэгдсэн удирдамж”-ийн 3.44-т “Ажил олгогчийн дэмжлэгийг зорилтот бүлгийн иргэнийг ажлын байраар хангаж, тасралтгүй 12 сар буюу түүнээс дээш хугацаагаар ажиллуулсан, цаашид үргэлжлүүлэн ажиллуулах ажил олгогчид олгоно” гэснийг мөрдөж ажиллаж, ажил олгогчийн урамшуулалд хамрагдсан иргэдийг мэдээллийг авч тулгалт хийх нь зүйтэй байна.

Сангийн хөрөнгийн зарцуулалт, авлагын барагдуулалт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтөд тавих дотоод хяналтыг сайжруулж, баталсан төлөвлөгөөний дагуу хяналтыг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллах шаардлагатай байна.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

### 5.2 Зөвлөмж

1. **Авлага данс**

*<u>Илрүүлэлт</u>:* Аудитаар тайланд онд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээний эргэн төлөлтийн хуваарийг хийхдээ 2023 оны 06 сар, 09 сараас төлөхөөр хийсэн байна. Гэвч хөтөлбөрт хамрагдсан зарим иргэд дэмжлэгийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлт хийгээгүй байна.

Энэ нь эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээний 3.10-т заасан “Эргэн төлөлт хийх хуваарь” ийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө гэсэн заалттай нийцэхгүй байна.

ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

*Шийдвэрлэсэн нь*: Хөдөлмөр эрхлэлтийн сангаас санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгжийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлтийг хийж байхад хяналт тавин ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аудитаар тайланд онд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрны дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээний эргэн төлөлтийн хуваарийг хийхдээ 2023 оны 06 сар, 09 сараас төлөхөөр хийсэн байна. Гэвч хөтөлбөрт хамрагдсан зарим иргэд дэмжлэгийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөлт хийгээгүй байна. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Нийт | 1 | 0 | | | | | 1 | 0 |

---oOo---

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ